



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц, журмыг шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагын Эрхзүйн байдлын тухай хуулийн 7.1.9 дэх заалт, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын хамтарсан 2009 оны 84/223 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дэргэдэх Оюутны Хөдөлмөрийн биржийн дүрмийг 1 дүгээр, бүтцийг 2 дугаар, журмыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 17 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын орлогч дарга /Б.Сүнгээ/, Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга /Д.Оюунгэрэл/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БАТСАЙХАН

Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын
2011 оны 04 сарын 01-ны өдрийн
10 тоот тушаалын ...-р хавсралт

ОЮУТНЫ ХӨДӨЛМӨРИЙН БИРЖИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

Энэ дүрмийн зорилго нь Оюутны хөдөлмөрийн бирж (цаашид Оюутны хөдөлмөрийн бирж" гэх)-ийн үйл ажиллагааны зарчим, бүрэн эрхийг тодорхойлох, түүний удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Оюутны хөдөлмөрийн бирж нь "Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр"-ийн хүрээнд оюутан, залуучуудыг түр болон цагаар хөдөлмөр эрхлэн санхүүгийн орлогоо нэмэгдүүлэх болон бизнес эрхлэх ур чадвар олгох модульт сургалтанд хамруулж өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломж нөхцлийг нь бүрдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, суралцаж буй мэргэжлийнх нь дагуу ААНБ-уудад дадлагажуулан ажлын байран дээрх сургалтын тогтолцоог бүрдүүлэх улмаар мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, бүтээн байгуулалтын болон сайн дурын үйл ажиллагаанд татан оролцуулах зэргээр нийтийг хамарсан арга хэмжээнд хамруулан хөдөлмөрийг үнэлэх, хөдөлмөрийн харилцаа хууль эрх зүйн мэдлэг олгох зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэг бүхий төв байна.

- 1.1. Оюутны хөдөлмөрийн бирж нь зорилт үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон буй бусад холбогдох хууль, тогтоомжууд, "Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг удирдлага болгон ажиллана.
- 1.2. Оюутны хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, төсөл, хөтөлбөр, санхүү, техникийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаанд тулгуурлан ажиллана.

- 1.3. Оюутны хөдөлмөрийн бирж нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөрийн газраас үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө, дүрэм, журмыг батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.4. Оюутны хөдөлмөрийн бирж нь үйл ажиллагаандаа ХХҮГазрын даргын 2009 оны 89-р тушаалаар батлагдсан “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэхэд зуучлах ажлыг зохион байгуулах түр журам”-ыг мөрдөж ажиллана.

ХОЁР. Оюутны хөдөлмөрийн биржийн удирдлага зохион байгуулалт

- 2.1. Нийслэлийн хөдөлмөрийн газар нь оюутны хөдөлмөрийн биржийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, шуурхай удирдлагаар хангана.
- 2.2. Оюутны хөдөлмөрийн бирж нь Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэд үйл ажиллагаагаа явуулна.
- 2.3. Оюутны хөдөлмөр биржийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг хариуцсан орон тооны ажилтантай байна.
- 2.4. Оюутны хөдөлмөр биржийн ажилтан нь биржийн үйл ажиллагааны тогтвортой ажиллах нөхцөлийг хангах, бодлогын залгамж чанарыг хадгалах, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулах, хөдөлмөр эрхлэлтийн төрийн захиргааны төв байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлын үр дүнг байгууллагын өмнө тайлагнах үндсэн үүрэгтэй ажиллана.
- 2.5. Оюутны хөдөлмөрийн биржийн ажилтан нь төрийн албаны тухай хууль болон төрийн цалингийн нэгдсэн сүлжээнд заасны дагуу хөтөлбөрийн хүрээнд цалинжина.
- 2.6. Оюутны хөдөлмөрийн биржийн ажилтанг нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.
- 2.7. Оюутны хөдөлмөрийн бирж нь өөрийн вэб хуудас, мэдээллийн сүлжээтэй байна.

**ГУРАВ. Оюутны хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааны үндсэн чиглэл,
эрх үүрэг**

3.1 Үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг

3.1.1. Оюутны хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, хөдөлмөрийн хөлс, төгсөгчдын мэргэжлийн ур чадвар, ажил олгогчдын эрэлт хэрэгцээ зэргээр төрөлжсөн судалгааг тогтмол хийж холбогдох эрх бүхий төрийн захиргааны төв байгуулага, боловсролын байгууллагуудад уламжлах энэ чиглэлээр хамтарсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.1.2. Их дээд сургууль бүрт өөрийн суралцагч оюутныг ажлын байраар хангахад анхаарч ажиллах системийг бий болгох

3.1.3. төрийн болон төрийн бус өмчийн их, дээд, мэргэжлийн боловсролын сургуулиудтай нягт хамтран ажиллаж төгсөгчдийн талаарх мэдээллийг нэгтгэн хөдөлмөрийн зах зээл дээр нээлттэйгээр зарлах, энэ чиглэлээр сургууль тус бүртэй хамтран ажиллаж ажлын байрны захиалгыг оюутан залууст хүргэх.

3.1.4. Гадаадын болон дотоодын, хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагуудтай оюутны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг судлан хэрэгжүүлж, хувийн хэвшлийн болон боловсролын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

3.1.5. Оюутныг суралцаж байгаа мэргэжлийнх нь дагуу болон бусад ажлын байранд дадлагажуулан ажил хөдөлмөр эрхлүүлэх, ажил олгогч эздэд энэ талаарх мэдээ мэдээллийг өгч ойлголтыг дээшлүүлэх.

3.1.6. Оюутнуудыг хот суурингийн тохижилт, байгаль хамгаалах болон нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэх зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд татан оролцуулах тэдгээрт батлагдсан хөдөлмөрийн хөлсийг цагаар буюу өдрөөр тооцон олгох.

3.1.7. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд оюутны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлуудыг тусгах, санал болгох

3.1.8. Хөдөлмөр эрхлэлтийн талаар болон бусад холбогдох хууль тогтоомж болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулахад саналаа тусгах.

3.1.9. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд энэ чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдтэй оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар өргөн хүрээтэй хамтран ажиллах.

3.1.10. Ажлын байран дахь сургалтаар дамжуулан мэргэжил, ур чадвар эзэмшүүлэн хүний нөөцөө бүрдүүлэх тогтолцоог төлөвшүүлэхэд анхааран ажиллаж, ажил олгогчдыг энэ талаарх судалгаа, мэдээ, мэдээллээр хангах тэдгээрт чиглэсэн сурталчилгаа компанит ажлыг төлөөллийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

3.1.11. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санг бий болгож хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, боловсролын байгууллага, оюутан төгсөгчдыг холбосон мэдээллийн нэгдсэн сүлжээг үүсгэн түүний найдвартай үйл ажиллагааг хангах, олон нийтэд сурталчилан таниулахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.1.12. Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг төрийн байгууллагын зүгээс дэмжин иргэд, оюутан залуучуудыг түр болон цагийн ажлаар хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж цагийн ажлын тогтолцоог бий болгох.

3.1.13. Газар тариалан, ургац хураалт, байгалийн гамшиг зэрэг цаг үеийн ажилд оюутнуудыг зохион байгуулалтайгаар хамруулах ажлыг хамтран зохион байгуулах

3.1.14. ЕБС төгсөгчдөд мэргэжлээ хэрхэн зөв сонгох талаар мэдээлэл сурталчилгааг хийх

3.1.15. Оюутны бүтээлийн бирж байгуулж үзэсгэлэн худалдаа, хөдөлмөрийн өдөрлөг, яармаг зохион байгуулах

3.1.16. Оюутны хөдөлмөр эрхлэлт, цагийн ажлын тогтолцоог оновчтой хэрэгжүүлэн хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр амжилттай ажиллаж өөрийн хувь нэмрээ оруулж буй хувийн хэвшлийн байгууллагыг шагнаж урамшуулах энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах, олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.1.17. Оюутан залуусыг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх мэдлэг ур чадвар олгох чиглэлээр олон улсын хөдөлмөрийн байгууллагын модульт сургалтуудыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулж энэ чиглэлээр оюутан залууст мэдлэг олгох сургалт зохион байгуулах.

3.1.18. Хөдөлмөрийн зах зээлийн өнөө болон ирээдүйн төлөв байдлын талаар зөвлөгөө мэдээлэл, ажил олгогчдын ажлын байранд тавьж буй шаардлага эрэлт, хэрэгцээ, хөдөлмөрийн хөлс, ажлын байрны нөхцөл, чиг үүргийн талаар мэдээлэл зөвлөгөөг оюутан залууст өгөх, энэ чиглэлээр уулзалт ярилцлага зохион байгуулах.

3.1.19. Хөдөлмөр эрхэлж буй оюутан залууст холбогдох хууль эрх зүй орчин, бизнесийн орчны талаар зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах.

3.1.20. Оюутан залуусын хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой бичиг баримтын бүрдэлтийг хийх, олгох, хяналт тавих.

3.1.21. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын хандивлагч байгууллагуудад төслийн санал тавих шийдвэрлүүлэх.

3.1.22. Гадаадад суралцаж байгаа болон төгсөгчдийн мэдээлэл судалгааг гаргах, нэгтгэх

3.1.23. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи мэдээ тайлан, төгсөгчдийн бүртгэл судалгааг үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, коллеж, МСҮТ-ээс гаргуулан авах.

3.1.24. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, МСҮТ-үүдэд салбар төвүүдийг байгуулан ажиллах.

ДӨРӨВ. Оюутны хөдөлмөрийн биржийн санхүүжилт, тайлагнал

4.1. Оюутны хөдөлмөрийн бирж нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн хөдөлмөрийн газарт сар, улирал, жилээр ажлаа тайлагнана.

4.2. Оюутны хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааны зардлыг “Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-өөс санхүүжүүлж үр дүнг тооцно.

4.3. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр хүрсэн үр дүнг санхүүжүүлэгч болон донор байгууллагад цаг тухай бүр нь тайлагнах.

4.4. Төсөл, хөтөлбөр, зээл тусламж санхүүжилтийг эрх хэмжээний хүрээнд холбогдох хууль, дүрмийн дагуу захиран зарцуулах.

4.5. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор дэд хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын хэрэгжилт, НХХЯ, ХХҮГ болон Нийслэлийн хөдөлмөрийн газартай байгуулсан гэрээний биелэлт, дэд хөтөлбөрийн тусгагдсан үйл ажиллагааны тайлан, мэдээг үнэн зөв гаргах.

ТАВ. Бусад

5.1. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

5.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-оОо-

Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын
2011 оны 04 сарын 01-ны өдрийн
10... тоот тушаалын 2...-р хавсралт

1. Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дэргэдэх Оюутны Хөдөлмөрийн
биржийн ажилтан – 2

Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын
2011 оны 04 сарын 01 -ны өдрийн
10 тоот тушаалын 3 -р хавсралт

ОЮУТНЫ ЦАГААР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр”-ийн хүрээнд оюутнууд чөлөөт цагаараа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, цагийн ажлын тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр” цаашид “хөтөлбөр” гэх \ нь оюутныг түр болон цагаар хөдөлмөр эрхлэх орлогоо нэмэгдүүлэх болон бизнэс эрхлэх ур чадвар олгох модульт сургалтанд хамруулж өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломж нөхцлийг нь бүрдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, суралцаж буй мэргэжлийнх нь дагуу ААНБ-уудад дадлагажуулах ажлын байран дээрх сургалтын тогтолцоог бүрдүүлэх улмаар мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, бүтээн байгуулалтын болон сайн дурын үйл ажиллагаанд татан оролцуулах зэргээр нийтийг хамарсан арга хэмжээнд хамруулан хөдөлмөрийг үнэлэх, хөдөлмөрийн харилцаа хууль эрх зүйн мэдлэг олгох зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.3 Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны зардлыг “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр”-өөс санхүүжүүлнэ.
- 1.4 Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг НХХ сайд, БСШУ-ны сайд хамтран баталж, цагаар хөдөлмөр эрхлэх журмыг Нийслэлийн хөдөлмөрийн газар баталж мөрдөн ажиллана.
- 1.5 Оюутны хөдөлмөрийн бирж нь Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэд үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Оюутны цагийн хөдөлмөр эрхлэлт

- 2.1 “Цагийн ажлын байр” гэдэг нь: Оюутнууд хичээлийн бус цагаараа оройн 22:00 цаг хүртэл хугацаанд 6 цагаас илүүгүйгээр аливаа ажил үйлчилгээг хийж гүйцэтгэж болох ажлын байр юм.

Гурав. Цагийн ажлын үргэлжлэх хугацаа

- 3.1 Оюутны ажиллах хугацаа 7 хоногт 30 цаг, өдөрт 6 цагаас илүүгүй байна.

3.2 Өдөрт 22.00 цагаас хойш ажиллуулахгүй байна.

3.3 Оюутны цагийн ажлын үргэлжлэх хугацаа 1-3 сар байна.

3.4 Цагийн ажил хийх оюутан нь "Оюутны паспорт"-той байна.

3.5 Оюутны цагийн ажлаар хийж болохгүй ажлын байрны жагсаалтыг гаргаж мөрдөнө. \хавсралтаар гарна\

Дөрөв. Цагийн ажлын хөлсны хэмжээ, санхүүжилт

4.1 Цагаар ажил хийж буй оюутны ажлын хөлсний 50 хувийг хөтөлбөрөөс санхүүжүүлнэ.

4.2 Мэргэжлийн дагуу дадлагажиж байгаа оюутны ажлын хөлс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна

4.3 Журамд заасан хугацаанаас илүү цагаар ажиллуулах шаардлагатай бол илүү цагаар ажиллуулсан хөлсийг тухайн аж ахуйн нэгж олгоно.

4.4 Цагийн ажлын хөлс 1 цагийн 1000-1500 төгрөг байна.

4.5 Бүтээн байгуулалтын болон сайн дурын ажиллагаанд татан оролцуулах зэргээр нийтийг хамарсан арга хэмжээнд хамруулан хөдөлмөрийг үнэлэх

4.6 Цагийн ажлын хөлснөөс ХАОАТ-аас өөр татвар авахгүй . Цагийн ажлыг олноор бий болгосон ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу дэмжин урамшуулна.

Тав. Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагын хариуцлага

5.1 Оюутныг биеийн хүч шаардсан хүнд хөдөлмөр эрхлүүлэхгүй.

5.2 Оюутны паспорт дээр ажилласан тэмдэглэгээг хийж байна.

5.3 Цагийн ажил хийж буй оюутны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг тухайн аж ахуйн нэгж байгууллага хариуцна.

Зургаа. Аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах

6.1 Аж ахуйн нэгж байгууллага нь Нийслэлийн Хөдөлмөрийн газарт оюутан цагаар авч ажиллуулах хүсэлтийг ирүүлсэн байна.

6.2 Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт нь газрын даргын цохолтоор баталгаажсан байх бөгөөд Оюутны хөдөлмөрийн биржид бүртгэлтэй оюутан залуучуудыг зуучлан ажиллуулсан байна.

Долоо. Тайлан мэдээ

Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг өдөр тутам оюутны хөдөлмөрийн бирж, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүд явуулж, Нийслэлийн Хөдөлмөрийн газар мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. Хөтөлбөрийн хүрээнд цагийн ажилд хамрагдсан оюутны тоо, нийтийг

хамарсан ажилд хамрагдсан оюутны тоо болон хийгдэж буй ажлын талаарх тайлан мэдээг улирал, жилээр гаргаж ХХҮГ-т мэдээлнэ.

-oOo-